АЯЛАЛ БҮХЭН ДАВТАГДАШГҮЙ

ЭРЭЭН – ЖАНЖИАКӨҮ – ТЯНЬЖИН – БЭЭЖИН (ХУДАЛДАА)

ҮНЭ

ОГНОО	ТОМ ХҮН	ХҮҮХЭД	НЯРАЙ
2026-11-19	1,290,000₮	990,000₮	Үнэгүй
2026-12-03	1,290,000₮	990,000₮	Үнэгүй
2026-12-17	1,290,000₮	990,000₮	Үнэгүй
2026-12-22	1,290,000₮	990,000₮	Үнэгүй
2026-12-29	1,290,000₮	990,000₮	Үнэгүй

ХӨТӨЛБӨР

ЭРЭЭН – ЖАНЖИАКӨҮ – ТЯНЬЖИН – БЭЭЖИН (ХУДАЛДАА)

1 УЛААНБААТАР – ЗАМЫН ҮҮД

- УБ - Замын Үүд чиглэлийн галт тэрэг 16:40-д хөдлөх бөгөөд 1 цагийн өмнө галт тэрэгний буудал дээр цуглана.

Өглөөний цай Багтаагүй | Өдрийн хоол Багтаагүй | Оройн хоол Багтаагүй

2 ЗАМЫН ҮҮД – ЭРЭЭН – ЖАНЖИАКӨҮ

- Өглөө 07:20 цагт Замын Үүдэд буугаад автобусанд сууж хил гаалиар нэвтэрнэ.
- Эрээн хотод түр амарч, өдрийн хоолоо өөрсдөө иднэ.
- Дараа нь автобусаар Жанжиакөү хотыг зорино.
- Оройн хоолны дараа Жанжиакөүгийн шөнийн захад чөлөөт цагтай.

Жанжиакөү

Өглөөний цай Багтаагүй | Өдрийн хоол Багтаагүй | Оройн хоол Багтсан

3 ЖАНЖИАКӨҮ – ТЯНЬЖИН

- Өглөөний цайны дараа Тяньжин хотыг зорино.
- Таван өргөн чөлөөгөөр аялна.
- Ойролцоогоор 1.28 км² талбайтай энэ бүс нь Англи, Франц, Итали, Герман, Испани зэрэг орны архитектурын хэв маяг, Сэргэн мандалтын, сонгодог болон барокко шийдлийг нэг дор харуулдаг.
- Дараа нь алдартнуудын лаан баримлын музейг үзнэ.
- Тус музейд улс төр, цэрэг, шинжлэх ухаан, урлаг, спорт, соёл, бизнесийн салбарын 200 гаруй хүний лаан баримал бий.
- Эртний соёлын гудамж болон Хүнсний гудамжаар зочилж, уламжлалт гар урлал, нутгийн алдартай дэлгүүрүүд, Тяньжиний бууз болон амттануудтай танилцана.
- Гудамжны төвд байрлах Тяньхоу сүм нь хотын түүхийг гэрчлэх дурсгалт газар юм.
- Эцэст нь «Бяцхан Ром» хэмээн нэрлэгддэг Хайхэ голын Европ хэв маягийн гудамжаар аялна.
- Оройн хоолны дараа зочид буудалдаа амарна.

Тяньжин

Өглөөний цай Багтсан | Өдрийн хоол Багтаагүй | Оройн хоол Багтсан

4 ТЯНЬЖИН – БЭЭЖИН

- Өглөөний цайны дараа Тяньжин хотод чөлөөт цаг өнгөрүүлнэ.
- Дараа нь Гуань олон улсын худалдааны хот буюу Юндинчэн худалдааны цогцолборыг зорино.
- Энэ төвд Бээжин орчмын худалдааны бүсүүд болон улсын үйлдвэрлэлийн бүсээс ирсэн 4000 гаруй худалдаа эрхлэгч, үйлдвэрлэгч ажилладаг.
- Эмэгтэй, эрэгтэй хувцас, өвлийн хүрэм, гутал, өмд, хүүхдийн хувцас, цүнх, арьсан эдлэл, сүлжмэл дотуур хувцас зэрэг олон төрлийн бараатай тул нэг дороос худалдан авалт хийх боломжтой.
- Мөн Бээжингийн «Шувууны үүр» цэнгэлдэх хүрээлэн болон «Усан шоо» цогцолборын гадна үзэмжийг үзэж, оройн хоолоо зооглоод зочид буудалдаа амарна.

Бээжин

Өглөөний цай Багтсан | Өдрийн хоол Багтаагүй | Оройн хоол Багтсан

5 БЭЭЖИН

- Өглөөний цайны дараа Бээжинд бүтэн өдрийн чөлөөт цагтай.
- Хүсвэл Бээжингийн Universal Studios амралтын цогцолборт өдрийг өнгөрүүлж болох бөгөөд тасалбар болон бусад зардлыг аялагч өөрөө хариуцна.
- Цогцолборт Universal сэдэвчилсэн парк, Universal CityWalk болон хоёр амралтын зочид буудал багтдаг.
- Кун-фу Панда, Трансформерс, Минионууд, Харри Поттерын шидэт ертөнц, Юрийн галавын ертөнцийн Нублар арал, Холливуд, Ирээдүйн усан ертөнц гэсэн долоон сэдэвчилсэн бүстэй.
- Мөн 37 тоглоом, үзвэр, 24 тайзны үзүүлбэр, 80 хоолны газар, 30 худалдааны цэгтэй.

Бээжин

Өглөөний цай Багтсан | Өдрийн хоол Багтаагүй | Оройн хоол Багтаагүй

6 БЭЭЖИН – ЭРЭЭН

- Өглөөний цайны дараа автобусаар Эрээн хотыг зорино.
- Замдаа аутлет худалдааны төвөөр орно.
- Эрээнд хүрэлцэн ирсний дараа чөлөөт цагтай бөгөөд оройн хоолоо зооглоод зочид буудалдаа байрлана.

Эрээн

Өглөөний цай Багтсан | Өдрийн хоол Багтаагүй | Оройн хоол Багтсан

7 ЭРЭЭН – ЗАМЫН ҮҮД

- Өглөөний цай.
- Эрээн хотод чөлөөт цаг өнгөрүүлнэ.
- 12.00 цагт хил гаалиар гарч Замын-Үүдэд ирнэ.
- 18.00 цагт хөдлөх Замын-Үүд УБ чиглэлийн галт тэргэнд сууна.

Өглөөний цай Багтсан | Өдрийн хоол Багтаагүй | Оройн хоол Багтаагүй

8 УЛААНБААТАР ХОТ

- Өглөө 09.20 цагт Улаанбаатарт ирснээр манай аялал өндөрлөнө.

Өглөөний цай Багтаагүй | Өдрийн хоол Багтаагүй | Оройн хоол Багтаагүй

ЗУРАГ

Аяллын зургууд





